

**ЗҮҮН АЗИЙН ЗАРИМ ОРНЫ ХӨГЖЛИЙН ТУРШЛАГА БА  
МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БОДЛОГО****Ё.Довчин** доктор, тэргүүлэх профессор**Ч.Өлзийсайхан** доктор, дэд профессор

1990-ээд оноос хойш манай улсын улс төр-нийгэм эдийн засгийн хөгжлийн голлох номлол нь либерализм болж, энэ зарчимд тулгуурласан чөлөөт зах зээлийн үзэл санаа ноёрхож байна. Хэдийгээр улс төрчид, улс төрийн намууд өөрсдийн үзэл баримтлалаа социал демократ, зүүн төвийн гэх мэтээр нийгмийн дийлэнхи олонхийн амжиргааны түвшинд тааруулсан байдлаар зарлаж байгаа боловч аль ч улс төрийн хүчин өөрийн тунхаглан байгаа чиг шугамаа баримтлахгүй, төлөвшлийн шатандаа явж байна<sup>95</sup>. Зах зээлийн эдийн засгийн талаасаа авч үзвэл бараг ямарч зохицуулалтгүй байна. Нэр хүндтэй улс төрчид, судлаачид ч либерал зарчмыг түлхүү баримталсан шинжтэй, олон улсын нөлөө бүхий байгууллагуудын өмнө иймэрхүү эдийн засгийн бодлогыг баримтлах үүрэг хүлээж байна гэж хэлж болно. Гэтэл үнэхээр либерализмын ноёрхол манай орны хөгжлийн гол баримтлал болж чадах уу, өндөр хөгжилд хүрсэн орнуудын үүх түүх үүнийг гарцаагүй нотлож байна уу гэж дэнслэн үзвэл энэ нь эргэлзээ төрүүлдэг. Юуны өмнө бид өнгөрсөн 20 гаруй жилд чөлөөт зах зээлийг урсгалаар нь хэрэгжүүлж ирсэн. Өнөөгийн эдийн засгийн байдал, улс ардын аж ахуйд голлох үүрэг гүйцэтгэх салбарууд тухайлбал, уул уурхай, мөнгө санхүүгийн бодлогод төрийн дорвитой бодлого, үнэхээр байна уу гэдэг нь санаа зовоосон асуудал болж хувирсан.

Эдийн засгийн сайн бодлого бол сайн улс төрийн бодлого гэсэн үүднээс үзвэл ирээдүй хэрхэн төсөөлөгдөж байна гэж дүгнэхийн тулд чөлөөт зах зээл, чөлөөт өрсөлдөөнийг шүтэх үзлийн үндсэн зарчмын зах зухаас нь авч үзье. Людвиг фон Мизес “Либерализм” хэмээх бүтээлдээ “Хүмүүс үндэсний ашиг сонирхол, хүн төрөлхтөний ашиг сонирхол хоёрын хооронд эвлэршгүй зөрчил бий гэж үзээд дэлхийн хүн төрөлхтөний сайн сайхны төлөө байгаа хүмүүсийг үндэсний ашиг сонирхлыг хөсөрдүүлсэн гэж шүүмжилдэг. Гэтэл энэ бол худлаа. Хүн төрөлхтөний сайн сайхны төлөө байгаа хүн, жишээ нь герман үндэстэндээ илүү хохирол учруулна гэдэг худлаа”<sup>96</sup> гэж олон улсын хэмжээнд чөлөөт зах зээл, хүний эрх, эрх чөлөө баталгаажих гол үндэслэлээ гаргаж тавьсан байдаг. Түүнчлэн “Хаа сайгүй хувийн өмчийг тууштай хамгаалж чадвал дайн дууссаны дараа ч хувийн өмчийг нь өөр хүн эзэмших боломж байхгүй болно, ийм учраас дайн үүсэх шалтгаан арилна”<sup>97</sup>. “Либерал зарчимд тулгуурласан капитализмд “эдийн засгийн онцгой бүс” гэж байдаггүй. Капитализмд ертөнцөд дэлхийн бүх гадарга эдийн засгийн нэгдмэл нэг газар нутаг байдаг”. “Чөлөөт худалдааны онолчид засгийн газарт хандан “хэрэв засгийн газар хөндлөнгөөс оролцохгүй байвал бүх орон бусад орнуудтай харьцуулахад үйлдвэрлэлийн нөхцөл ямар байгаагаас үл шалтгаалан дэлхийн эдийн засагт өөрийн байр сууриа хэзэлж чадна”<sup>98</sup> гэж хэлнэ” гэх зэргээр дээрхи бүтээлд өгүүлсэн байдаг.

<sup>95</sup> Монголын ардчиллын төлөвшил. МУ-ын ШУА. ФСЭХ. УБ.2011. 111-121 дахь талууд

<sup>96</sup> Людовиг фон Мизес. Либерализм. х.117

<sup>97</sup> Мөн тэнд. х.117

<sup>98</sup> Мөн тэнд. х.133

Аливаа улсын төрийн бодлого бол улс орноо хөгжүүлэх, хөгжлийн ололтыг ард түмнийхээ аж амьдралыг дээшлүүлэх, орлогыг аль болох тэгш хуваарилах явдлыг хангахад л чиглэгдэх ёстой. Улс орныхоо хөгжлийг хангаж ард түмний амжиргааг бодитойгоор дээшлүүлж чадахгүй л юм бол ямарч ардчилал, ямар ч зөв улс төрийн бодлогын тухай яриад хэрэггүй юм. Харин улс оронд явуулж буй эдийн засгийн бодлого нь үнэхээр нийтийн эрх ашигт нийцэж байгаа бол улс төрийн бодлого зөв байна гэж үзэх нь оновчтой санагдана.

Тэгэхээр улс төрийн шинжлэх ухаан, эдийн засгийн бодлоготой улам бүр уялдаа холбоотой болж, улс төрийн эдийн засгийн мэдлэг ухааны салбар эрчимтэй хөгжиж буй. Энгийнээр хэлбэл шаардлага хангахгүй төрийн бодлоготой байхад ямар ч сонгуулийн цэвэр технологи, намын дотоод ардчиллын тухай ярих нь утгагүй бөгөөд зөвхөн ашиг хонжоо, давуу байдал олж буй цөөн хэсэг ардчилал гэсэн өнгөлөн далдлалтаар бүх зүйлийг хийх нь улс төр эдийн засгийн гүнзгий хор уршиг дагуулах болно. Ер нь хаана ч ардчиллыг өө сэвгүй бий болгосон төр улс байхгүй. Тэгэхээр нэгэнт байдал ийм учраас илүү тодорхой үр дүнгийн асуудлыг хөндөж ярих нь зүйтэй юм.

Ардчилал хөгжсөн орнуудын пүүс компаниуд бүхэн хүнлэг энэрэнгүй, олон улсын байгууллагууд бүхэн улс орон бүрийг адил тэгш хөгжүүлэх бодлого баримтладаг гэж ойлговол хэт өрөөсгөл юм. Манай улсын эдийн засгийн бодлогод их нөлөөтэй байгаа ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд өөр сонголттой бодлогын талаар нухацтай шүүн хэлэлцэж аль аль талыг нь харгалзан үздэг гэдэг нь тийм ч баталгаатай бус юм. Энэ талаар Нобелийн шагналт эдийн засагч Жозеф Стиглиц “Урьд өмнө улс орнуудад явуулж байсан бодлогын стандартаа улс орон бүрт адилхан тохирох ёстой гэж үзэх нь ч оновчтой биш юм. Зах зээлийн эдийн засаг нь ашигтай үр дүнд аяндаа хүргэнэ гэсэн ойлголт нь улс орнуудын хөгжлийн түвшин эрс тэс ялгаатай байгаа өнөөгийн нөхцөлд хөгжиж буй орнуудад явч ашигтай байдал авч ирэхгүй”<sup>99</sup> гэж тэмдэглэсэн байдаг нь өнөөгийн монгол орны хөгжлийн байдал, төрөөс баримтлаж байгаа бодлогыг л харж шүүмжилсэн мэт санагдана.

Хүмүүс хувийнхаа амьдралыг өөрсдийн санаа бодлыг харгалзан үзэхгүйгээр хэзээ ч сохроор бусдын үгийг дагаж явуулдаггүйн нэгэн адил улс орны хувь заяаны асуудлыг гаднаас шууд тулган хүлээлгэсэн бодлогоор улс төрийн бодлогыг явуулна гэвэл сүйрэл, ядуурал дагуулахаас хэтрэхгүй юм<sup>100</sup> гэж Ж.Стиглиц үзсэн юм. Тэгвэл яг энэ чиглэлд хөтлөгдөн хөгжлийн хурдац, түвшингээр дэлхийн бусад орнуудад үлгэр жишээ болж байгаа орнууд ямар улс төрийн бодлогыг түлхүү явуулж байсан бэ гэдгийг зах зухаас нь авч үзэхийг оролдоё.

### Хятад

Дэлхийн улс орнуудын дунд хөгжлийн хурдац, загвараараа гайхагдаж буй орон болох Хятад нь өөрийн оюуны нөөц, өөрийн хүч чадалдаа дулдуйдан эрчимтэй хөгжлийн замд орж чадсан хүчирхэг гүрэн юм. Хятад улс өнөөгийн манай улсын баримталж байгаа шиг гадаадын тусламж, зөвөлгөөнд шүтсэн бодлого нэг их баримтлаагүй гэж хэлж болно. Хятад орон эдийн засгаа өөрчлөн хөгжүүлэхдээ олон улсын байгууллагаар удирдуулаагүй. Тэр ч байтугай Малайз ба Хятад хоёр ОУВС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхгүй гэж шийдсэн орнууд юм.

<sup>99</sup> Жозеф Стиглиц. Дэлхийчлэл ба түүний сэтгэлд эс нийцэх нь. УБ., 2007. х.16

<sup>100</sup> Жозеф Стиглиц. Дэлхийчлэл ба түүний сэтгэлд эс нийцэх нь. УБ., 2007, х.17

Дэлхий дахины эдийн засгийн хямралаас хамгийн бага хохиролтой гарч чадаж байгаа хоёр том орон болох Энэтхэг ба Хятад нь хоёулаа гадаадын хөрөнгө оруулалтанд хяналт тавьж байгаа нь ч тохиолдлын хэрэг биш юм. Хямралын үеүдэд чөлөөлөгдсөн хөрөнгийн зах зээлтэй хөгжиж байгаа орнуудын орлого буурсан байхад Энэтхэгийн эдийн засаг жилд 5 хувиар, Хятадынх 8 орчим хувиар өссөн юм. Хятад нь эдийн засгийн хуучинсаг итгэл үнэмшлийг удирдамж болгон амжилтанд хүрсэн бөгөөд ОУВС-ийн маягийн удирдамж биш, харин ч хагас зуу гаруй жилийн туршид эдийн засагчдынхаа зааж ирсэн удирдамжыг чухалчилж байсан. Хятад нь богино хугацааны хэрэгцээгээ урт хугацааны өсөлтийн зорилготой хослуулахад энэ удирдамжаа ашигласан болно.

Жозеф Стиглиц хөгжиж байгаа орнуудад олон улсын байгууллагуудын баримтлаж байгаа бодлогуудад маш их шүүмжлэлтэй хандсан байдаг бөгөөд “хэдийгээр хямрал давтагдах, аль эсвэл түргэн сэргэлт гарахад тухайн өөр өөр нөхцөл байдлын учир шалтгааныг тогтооход хэцүү ч гэсэн Зүүн Азийн цорын ганц том орон болох Хятад нь хямралд орохгүйн тулд ОУВС-ийн дэмжиж буй чиг шугмаас эрс өөр чиг баримтласан ба богинохон уналттай Малайз бас ОУВС-гийн стратегиэс зориуд татгалзсан зэрэг нь санаандгүй явдал биш гэж би боддог<sup>101</sup> гэж бичсэн байдаг. Олон улсын байгууллагуудын удирдлага дор зохион байгуулсан Оросын шилжилт, өөрсдөө хийсэн Хятадын шилжилт хоёрыг харьцуулан үзэхэд эрс ялгаа харагддаг байна. 1990 онд Хятадын ДНБ Оросын ДНБ-ний 60% байсан бол 10 жилийн дараа гэхэд яг эсэргээрээ болсон байжээ.

#### АНУ

Хэдийгээр бид энэ өгүүллээ зөвхөн азийн орнуудын жишээн дээр голлон тулгуурлаж бичихийг зорьсон боловч дэлхийн олон оронд ардчилалыг түгээн дэлгэрүүлэгч гэж нэрлэгддэг АНУ жинхэнэ утгаар нь, өөрөөр хэлбэл сонгодог либерализмын үндсэн зарчмуудыг гуйвалтгүй баримтлан хөгжиж ирсэн болов уу гэж бас харьцуулан үзэх нь асуудлыг илүү тод томруун харуулах тул энэ орны хөгжлийн түүхийн зарим хэсгээс нь авч үзэж байна.

Ардчиллын эх орон Америк үнэхээр чөлөөт зах зээлийн эдийн засгийг бүрэн утгаар нь хэрэгжүүлж байна уу гэдгийг эрэгцүүлж харвал бас нилээд сонин дүр зураг харагдаж байна.

Людовиг фон Мизес “Чөлөөт худалдааны эх орон Англид хүртэл өнөөг хүртэл протекционист бодлого зонхилж байна. Гадаадад бага зардлаар бий болсон бараанд үнийн зөрүүтэй нь адил болгосон тариф нэмж тогтоох нь АНУ-ын гадаад бодлогын гол үзэл суртал болж байна”<sup>102</sup> гэх зэргээр гадаадаас оруулж ирэх бараанд татварын өндөр тариф тогтоож үндэсний үйлдвэрлэлээ хамгаалдаг бодлогыг буруушаасан байх ажээ.

Түүх сөхөж харвал АНУ, Япон болон бусад аж үйлдвэр өндөр хөгжсөн орнууд гадаадын компаниудтай өрсөлдөхийн өмнө аж үйлдвэрээ ухаалгаар хамгаалж байж эдийн засгаа хөгжүүлсэн байдаг. Эдгээр өндөр хөгжилтэй улс орнууд өнөөдөр ядуу буурай орнуудыг протекционист бодлого явуулахыг хориглож байдаг боловч өөрсдөө хөгжиж буй болон бусад орнуудын экспортод саад хийсээр ирсэн ажээ. 1995 оны дундуур Япон болон АНУ-ын хооронд хурцадмал байдал үүссэн бөгөөд үүний учир нь АНУ-ын Засгийн Газар Японы тансаг машины импортод

<sup>101</sup> Эдийн засгийн ухааны Нобелийн шагналтан Жозеф Стиглиц Дэлхийчлэл ба түүний сэтгэлд эс нийцэх нь. УБ., 2007, х.182

<sup>102</sup> Людовиг фон Мизес Либерализм. х.133

хамгаалалтын тариф тогтоосон байдаг. Сүүлийн жилүүдэд ч АНУ-д бүтээгдхүүнээ худалдаалж байгаа Японы машин үйлдвэрлэгчид АНУ-ын засаг захиргааны зүгээс ихээхэн дарамт шахалтан дор үйл ажиллагаагаа явуулж байна.

ОУВС, дэлхийн банкны зүгээс хөгжиж байгаа орнуудад банкны системээ гадаад орнуудад чөлөөтэй болгох, зах зээлийн хуулиар чөлөөтэй зохицуулагддаг байхыг шаардаж байдаг. Гэтэл АНУ, Европын орнуудын банкны системийг чөлөөлөх үйл ажиллагаа 1970 оноос хойш л хийгдсэн байдаг ажээ. Өөрөөр хэлбэл эдгээр орны банк санхүүгийн систем нь бусад орны ижил төстэй байгууллагуудын үйл ажиллагаанаас огт айхгүй хүчирхэг болсон үедээ л гадаадынханд чөлөөтэй нэвтрэх боломж олгожээ.

Өндөр хөгжилтэй орнууд худалдааг чөлөөлөх, хязгаарлах, квот тогтоох, хориглох улс төрийн бодлогоо өнөөдөр ч түгээмэл хэрэглэсээр л байна.

- АНУ компьютерийн хөгжил судалгааны асуудалд Хятадад хяналт тавьдаг.

- АНУ Европын орнуудаас импортоор орж ирэх хөдөө аж ахуйн бүтээгдхүүнд хязгаарлалт тогтоосон.

- Бушийн засгийн газар АНУ-ын ган үйлдвэрлэгчдийг хамгаалахын тулд импортоноос татвар тариф ногдуулсныг дэлхийн ган үйлдвэрлэгч улсууд Япон, Европын холбоо, Солонгос, Бразил, Тайвань, Орос, Герман, Турк, Франц, Хятад Австрали, Нидерланди гэх мэт улсууд эсэргүүцсээр байна.<sup>103</sup> Гэтэл хөгжиж буй орнуудад ийм хамгаалалтын тариф тогтоохыг ОУВС, Дэлхийн Банк зэрэг байгууллагууд шууд хориглож байдаг ажээ. Тухайлбал, манай орон ч энэ хориг саадыг туулж, бодлогын хувьд ямар нэг хэмжээгээр хараат явсаар ирсэн. Хэдэн жилийн өмнө дотооддоо өндөр технологээр пиво үйлдвэрлэх боломжтой болсон учраас гаднаас орж ирэх ийм төрлийн бүтээгдхүүнд өндөр татвар оногдууж дотоодын үйлдвэрлэлээ дэмжих бодлого Монгол Улсын засгийн газраас баримтласан бөгөөд энэ нь ОУВС, Дэлхийн Худалдааны Байгууллагын шахалтаар цуцлагдсан билээ

Бидний хөгжлийн гол бодлогоо болгож сонгосон чөлөөт зах зээлийг шүтсэн, ямар нэг протекционизмгүй, гадаад дотоодын хөрөнгө оруулагчидад адил тэгш эрх олгосон, хяналтгүй байгаа бодлогыг эрх чөлөөний орон Англи, Америкт яагаад хэрэгжүүлэхгүй байна вэ гэдгийг эрэгцүүлэн бодох нь гарцаагүй зүйл биш үү.

## Япон

*17-18-р зуунаас хөгжиж ирсэн капиталист нийгмийн түүх, европын өндөр хөгжилтэй орнууд, Япон, Хятад орнуудын хөгжил өөрийн гол үйлдвэрлэл, санхүүгээ хамгаалж ирсэн бас л адил зүй тогтлоор явж иржээ. Ийм хамгаалалт нь тухайн орны эдийн засгийн хамгийн чухал салбарууд хөл дээрээ баттай зогсоход юутай ч зүйрлэшгүй тус дэм болсон байдаг байна. Гадаадын техникийг нэвтрүүлэх хөрөнгө оруулах асуудал нь Японы худалдаа, аж үйлдвэрийн яамны мэдэлд бүрэн байсан бөгөөд одоо ч байсаар байна.*

Японы засгийн газраас улс орныхоо эдийн засгийн чухал салбарт гадаадын капиталын монополь байр суурь эзлүүлэхгүйн тулд тодорхой арга хэмжээ авч, хэрэгжүүлж иржээ. 1950 онд баталсан "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай" хууль нь хэрэг дээрээ гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан байдаг. 1950-иад оны эхэн гэхэд Япон нь гадаадын хөрөнгө оруулахад хамгийн хаалттай орон байсан юм. 1967 он хүртэл эдийн засгаа эрчимтэй хөгжүүлэхийн тулд гадаадын зээлийг тодорхой хэмжээгээр авч байсан боловч шууд хөрөнгө оруулалтыг хязгаарлахад

<sup>103</sup> Т.Ганхүү. Олон Улсын Маркетинг УБ., 2008, х.46, 78

чиглэгдсэн бодлого нь АНУ болон бусад орны дургүйцлийг хүргэж 1967 оны 6-р сараас эдгээр орнуудын шаардлагаар гадаадын хөрөнгө оруулалтыг либералчлах бодлого хэрэгжиж эхэлжээ. Хэдийгээр либералчлах бодлогыг явуулсан ч гадаадын хөрөнгө оруулагчдад хориглосон салбарууд бас л үлдсэн юм. Тухайлбал,

- техник технологийн салбар
- экспортыг өргөжүүлэх салбар
- эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал салбар,
- дунд болон бага жижиг оворын үйлдвэр чухал байр суурь эзлэдэг

салбар эдийн засгийн зэргийг дурьдаж болно.

Япон улс гадаадын хөрөнгийг нэвтрүүлэхдээ засгийн газрын нарийн хяналтанд байлгах, эдийн засгийн тодорхой салбарт гадаадын монопольт байдлыг тогтоохоос сэрэмжлэх бодлого баримтладаг юм. Мөн дотоодын үйлдвэрийн газрын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд тэдгээрийн судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлэх санхүүгийн нөхцөл байдлыг баталгаажуулах зорилтыг тавьж хэрэгжүүлж иржээ. Харин Японы үндэсний үйлдвэрүүд монополь байр сууриа нэгэнт эзлэсэн хар төмөрлөг, хөлөг онгоц үйлдвэрлэлийн салбарт 100% гадаадын хөрөнгө оруулахыг зөвшөөрсөн байдаг нь гадаадын хөрөнгө оруулалт нь эдгээр үндэсний компаниудын хөгжилд нэгэнт саад болж чадахгүй гэж үзсэнийх байсан юм. Харин газар тариалан, ой, загасны аж ахуй, уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан байна.

Японы эдийн засгийн энэ ухаалаг бодлого нь улсынхаа эдийн засгийг хөгжүүлэхдээ гадаадын хөрөнгөд шүтсэн, яваандаа тэдгээр орны хараат байдалд орох биш, харин дотоодынхоо нөөц бололцоог илрүүлэн ашиглаж, санхүү, зээл, худалдааны чадварлаг зохицуулалтыг хангасан бодлого байсан бөгөөд энэ нь Япон орныг хөгжлийн өнөөгийн өндөрлөгт хүргэсэн билээ.

Японы эдийн засгийн эрчимтэй хөгжилд юуны өмнө санхүү, зээл, мөнгөний эргэлт, хөрөнгө оруулалтын үйл явц, шинжлэх ухаан технологийн хөгжил, эдийн засгийн гадаад харилцааг өргөжүүлэхэд төрийн монопольт зохицуулалт нэн чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Төрийн монопольт зохицуулалт санхүү, юуны өмнө хөрөнгө оруулалт, татварын бодлогод хамгийн их тусгагдаж хэрэгждэг байна.<sup>104</sup> Тэгвэл манай төрөөс явуулж байгаа бодлого үндэсний үйлдвэрлэл, үндэсний санхүүгийн байгууллагуудаа хэрхэн хамгаалдаг вэ гэдгийг японы туршлагатай харьцуулбал тэнгэр газар хоёр шиг зөрөөтэй байна. Арилжааны банкуудад хөрөнгө оруулагчид нь гадаадынхан байх бөгөөд Монгол Банк 2011 онд л жинхэнэ эздийг нь тодорхой мэдээллэхийг банкуудаас шаардаж байх жишээтэй. Нилээд банкуудын хувьцааны дийлэнхи хэсэг нь гадаадын бизнесменүүдийн мэдэлд байсныг ямар нэг маргаантай асуудал үүссэний дараа л нийгэмд мэдэгдэж ил болж байх жишээтэй. Ашигт малтмалынхаа ордуудыг үндэсний компаниуд нь өсч бэхжихээс нь өмнө гадаад иргэд, компаниудын мэдэлд лиценз хэлбэрээр өгчихсөн тэрч байтугай хайгуулын лицензээр ашиглалт явуулаад олон жил болчихсон, төр нь тэднийг яадаг ч үгүй байгаа нь төрөөс үндэсний үйлдвэрлэлээ хамгаалдаг америк, японы бодлоготой зүйрлэж үзэх нь нэгэнт утгагүй, тэнгэр газар шиг ялгаатай байх ажээ.

<sup>104</sup> ШУА-ийн Дорно дахин, олон улс судлалын хүрээлэн. Япон Азийн “барс” үсрэнгүй хөгжсөн нь. УБ., 1994, х.18

## Бусад орнууд

Хөгжлийн өндөрлөгт хүрсэн бусад улс орнуудад ч эдийн засгийн төлөвлөлт, аж үйлдвэрийн бүтцийн өөрчлөлт, техник технологийн бодлого зэрэг эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч салбарт төрийн хяналт оролцоо идэвхитэй бөгөөд өргөн байжээ.<sup>105</sup> Өнөөдөр манайд эдийн засаг дахь төрийн оролцоог аль болох хязгаарлах гэдэг үзэл ихээхэн дэлгэрсэн. Гэтэл улс ардын аж ахуйд хамгийн их нөлөөтэй салбартаа төрийн монополь тогтоож амжилтанд хүрч байгаагийн жишээ нь Чили улс юм. Хэдийгээр Чилид дарангуйлагч дэглэм удаан хугацаагаар ноёрхсон ч эдийн засгийн бодлого нь зөв чиглэлтэй явсан нь өнөөгийн хөгжлийн түвшинд хүргэжээ. 1976 онд төрийн өмчийн "Codelco" компанийг байгуулсан нь өнөөдөр зэсийн үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлж Чилийн эдийн засгийн хамгийн том тулгуур болж байна.

Сингапур улсад төр засаг нь үндэснийхээ эдийн засагт онцгой үүрэгтэй хэвээр байна. Энэ улсад үндэсний нийт бүтээгдхүүний 25%-ийг үйлдвэрлэж байдаг 450 компанийг улсын хяналтанд одоо ч гэсэн байлгасаар байна. Нийт үндэснийхээ эрх ашгийг хөндсөн ажил, үйлчилгээ эрхэлдэг компанийн үйл ажиллагаанд төрийн зүгээс хяналтаа хэвээр нь байлгаж, харин төрөөс оролцох шаардлагагүй холимог компанийн хувьцааг хувьд худалдахаар тогтжээ.

Гадаадын хөрөнгө оруулалт ямарч үүрэг гүйцэтгээгүй боловч Солонгос улс Японы нэгэн адил гайхамшигтай амжилтанд хүрчээ. Өмнөд Солонгос, Японы гайхамшигт амжилт нь өөрсдийнх нь үндэсний үйлдвэрүүд байсан юм. Өмнөд Солонгос нь олон улсын ихээхэн хөрөнгө оруулалтгүйгээр гучин жилийн туршид эдийн засгийн гайхалтай өсөлттэй байсан бөгөөд энэ нь тус орны өөрийнх нь хадгаламж, өөрсдөө удирдаж буй өөрийнх нь компаниудын хүчээр бий болсон. Өмнөд Солонгос зах зээлээ гадаадын компаниудад түргэн чөлөөлөх нь аюул дагуулж мэдэхийг урьдчилан тооцож алгуур аажим чөлөөлсөн байдаг. Төр өөрийн эзэмшилд байсан үйлдвэрүүдээ чөлөөлөхдөө ч, сул дорой байх үедээ өндөр хөгжилтэй орнуудын ижил төстэй үйлдвэрүүдтэй өрсөлдөөнд гарвал цохигдох аюултайг нь тооцож хувийн хэвшил рүү шилжүүлэх үйл ажиллагааг аажим, болгоомжтой хийсэн байдаг. Стратегийн томоохон зорилтуудыг шийдвэрлэхэд засаг төрийн удирдлагын үүрэг роль ингэж хүчтэй байсан явдал тус орны хөгжлийг хурдацтай урагш ахиулахад нөлөөлсөн нэг чухал хүчин зүйл болжээ. Ингэхдээ засгийн газар нь аж ахуйн стратегийн гол салбаруудыг хяналтандаа авч төлөвлөгөөтэйгээр удирдан зохион байгуулж ирсэн бөгөөд төлөвлөлтийн энэ систем нь хувийн секторыг эдийн засгийн хөгжлийн тулгуур үндэс болгоход чиглэгдсэн байна. Өнөөдөр ч Өмнөд Солонгост улсын үйлдвэрүүд чухал үүрэг гүйцэтгэсээр байна. Засгийн газар нь ган, бордоо үйлдвэрлэл зэрэг стратегийн чухал салбарууд дээрээ хяналтаа тавьсаар байгаа бөгөөд орон даяар 100 гаруй томоохон үйлдвэр ажилладагаас засгийн газрын шууд хяналтанд ихэнх нь байж байна.

Малайз улс нь Сингапур, Хятадын нэгэн адил нь гадаадын хөрөнгө оруулалтанд гажуудал гарахаас байнга сэргийлсэн бодлого явуулж иржээ. Эдгээр улсууд хөрөнгө бий болгох бизнес гэхээсээ илүү шинэ зах зээл бий болгох, шинэ технологи оруулж ирэх чиглэлд л гаднын хөрөнгийг ашиглаж ирсэн байна. Малайзад улсын сектор ихээхэн үүрэг гүйцэтгэсээр байна. Засгийн газар нь банк,

<sup>105</sup> ШУА-ийн Дорно дахин, олон улс судлалын хүрээлэн. Япон Азийн "барс" үсрэнгүй хөгжсөн нь. УБ., 1994, х.15

дэд бүтцийн барилга, тариалангийн талбай, теле нэвтрүүлэг, усан боомтуудын 50 гаруй байгууламжийг улсын хяналтанд байлгаж байна. Малайз орон хувьчлалыг нарийвчлан удаан хугацаанд судалсны дараа, увуу цувуу аажим хийжээ.

Өндөр хөгжсөн АНУ, европын орнуудын түүх, зүүн өмнөд Азийн үсрэнгүй хөгжсөн орнуудын түүх нь үнэхээр гадаад дотоодын хөрөнгө оруулалтанд яг адил тэнцүү зарчим биш харин үндэсний үйлдвэрлэлдээ илт давуу байдлыг бий болгосон, үүнийхээ үндсэн дээр хожиж гарсан байдаг түүх нь адил байдаг ажээ. Эдгээр орнууд нь зах зээлийн эдийн засгийг дэмжсэн, энэ чиглэлд бодлого явуулсан. Гэхдээ гадаад, дотоодын капиталуудад ялгаатай бодлого л баримтласанаараа адил билээ.

Амжилттай хөгжсөн орнуудын хөгжлийн нууц нь эдийн засгийн зөв бодлого явуулж, гаднаас орчин үеийн техник, технологийг цаг алдалгүй авч, ард түмэн нь шаргуу, тэсвэр тэвчээртэй чармайн хөдөлмөрлөсний л үр дүн, төр нь иргэддээ хөгжих боломжийг олгосонд л байгаа юм.

Азийн шинээр аж үйлдвэржсэн орнууд эдийн засгийн хөгжлийн хурдацаар хамгийн өндөр түвшинд хүрсний эх сурвалж нь

- үндэснийхээ давуу талыг чадамгай ашиглан төрөөс зөв зохицуулсан, тогтмол удирдлагаар хангасан.
- үйлдвэржилтийг экспортын чиглэлээр хөгжүүлсэн
- гадаадын капиталыг бодлоготой, зохицуулалттайгаар оролцуулсан.
- амьдрах чадвартай үндэсний монополь аж ахуй бий болгосон зэрэг хүчин зүйлтэй холбоотой болох нь харагдаж байна.

Улс төрийн тогтвортой байдал нь эдийн засгийн өсөлтийг хангах тааламжтай нөхцөлийг бүрдүүлдэг бол эдийн засгийн хөгжлийн амжилт нь эргээд эрх баригч намын давамгайл байдлыг баталгаажуулж өгдөг учраас дарангуйлагч дэглэмтэй улсууд ч эдийн засгийн ухаантай бодлогынхоо дүнд ард түмнээсээ өндөр үнэлгээ авч легитим байдлаа баталгаажуулж авах боломжтой болж байсныг эдгээр орнуудын түүх харуулж байна.

Гэтэл зарим улс орон маш их байгалийн баялагтай ч улс төрийн бодлого нь оновчгүй байсны улмаас өлсгөлөн ядуурал, иргэний дайнаас ангижирч чадахгүй байна. Улс төрийн буруу бодлого нь нэг талаас капитал гадагшаа урсах, нөгөө талаас ард түмний амжиргааны доройтол, сэтгэл дундуур байдал хоёрын хооронд зөрчил үүсч улс оронд хөгжих боломж олгохгүй хямралын гүн агнал руу чирч ордгийг африкийн олон орны туршлага нотлон харуулж байна. Байгалийн асар их баялаг, түүнийгээ гаднын капиталаас хамгаалаагүй төрийн буруу бодлого хоёр нь эдгээр орнуудын өлсгөлөн, зовлон, дайн, хямралын шууд шалтгаан нь болж иржээ.

Улс орны эдийн засгийг хөгжүүлэх гэвэл ардчилах, шударга чөлөөт өрсөлдөөнийг нэвтрүүлэхээс өөр зам үгүй гэдэг нь гарцаагүй. Гэхдээ чөлөөт өрсөлдөөн нь тухайн орны эдийн засгийг гаднын маш их капитал хуримтлуулсан корпорациудаас хамгаалсан, үндэснийхээ үйлдвэрлэлийг дэмжсэн чиглэлээр л явагдах ёстой.

Өөрөөр хэлбэл эдийн засгийг ардчилахдаа төлөвлөгөөтэй хөгжүүлэх, санхүүгийн өндөрлөг болон гол чухал аж үйлдвэрийн салбарыг төрийн хяналтанд байлгах чиг шугамыг баримтлах, гадаадын түнштэй хийх хэлэлцээнд хамгийн ашигтай нөхцлийг олж авах, нийт аж үйлдвэрийн технологийн шинэчлэлийн эрх ашгийг харгалзах зорилго тавьж байж л амжилтанд хүрэх нь гарцаагүй юм.

### Монгол Улс

Хөгжлийн өндөрлөгт хүрсэн улс орнуудын түүхийг харж үзвэл өөрийн монгол орны улс төрийн бодлого хэр зэрэг зөв явж байна вэ, улс орныхоо ирээдүйн хөгжлийг хангах ухаалаг бодлого явуулж байгаа болов уу гэж эрэгцүүлэн бодоход хүргэж байна. Өнөөдөр манай нийгэмд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого маш их хүчтэй яригдаж байна. Хөгжлийн замаа сонгохдоо ч гадаадынхны зөвөлгөө, олон улсын байгууллагуудын зөвөлгөө, тусламжинд л найдацгаадаг. Гэтэл хөгжсөн орнуудын түүх, бодлого нь илүү өөрсдийн хүчинд дулдуйдсан чиглэлтэй байна.

Манай монгол улс шиг хөгжиж байгаа орнууд гадаадын хөрөнгө оруулалтанд ямар нэг хэмжээгээр түшиглэх нь гарцаагүй зүйл юм. Гэхдээ энд гажуудал гаргаж болохгүй. Олон улсын байгууллагууд, дэлхийн банкнаас авч байгаа зээлүүд нь баялаг үйлдвэрлэх чиглэлд биш харин эргэж өр болон үлдэх чиглэлд л зарцуулагдаж байгаа нь эдийн засгийн үр өгөөж сайтай улс төрийн бодлого байсан гэхэд эргэлзээтэй. Хөгжиж байгаа олон орны хувьд ингэж баялаг үйлдвэрлэдэггүй чиглэлд авсан зээл нь тухайн орны эдийн засгийг туйлдуулж хөгжих боломж муутай болгодогыг төсвийнхөө тал хувийг өрөнд өгч байгаа Эквадор улсын жишээнээс харж болно. Монгол Улстай Дэлхийн Банк 19 жилийн турш хамтран ажиллаж байгаа бөгөөд энэ хугацаанд 29 төслийг хэрэгжүүлэхэд 422 сая долларыг олгоод байгаа. Энэ хөрөнгөнөөс 340 сая нь эдийн засгийн хөгжил, ашигт малтмалын нөөцийн менежмент, засаглал, дэд бүтэц, хүний хөгжлийн чиглэлд зарцуулжээ.

Манай улсын үндэсний аж үйлдвэр нь эрчимтэй хөгжилд хүрч хараахан чадаагүй байгаа, гарааны эхэнд байгаа энэ цаг үед өндөр хөгжилтэй орны хүчтэй аж үйлдвэрийн салбартай чөлөөтэй өрсөлдүүлэхээр төрийн зохицуулалтыг муу хийх, бараг хийхгүй байх, импортын бараанд зах зээлээ хэт чөлөөтэй нээх нь эдийн засгийн хувьд ч нийгмийн хувьд ч асар их хохиролтой. 1990 оноос эхлэн зах зээлийн эдийн засгийг хөгжүүлнэ гэж гадаадын капиталд хэт найр тавьсан бодлого явуулснаар өнөөдөр улс орны болон орон нутгийн хөгжилд нөлөө үзүүлэхүйц томоохон ордууд гадаадынхны мэдэлд очиж үүнээс үүдэлтэйгээр ард түмэн ч төр засагтаа үл итгэх байдал ихэсч эдийн засгийн энэ том салбараасаа өчүүхэн ашиг хүртэх үр дагаварт хүргэж нэгэнт гаргасан алдааг засах нь ихээхэн бэрхшээлтэй болж байна. Тухайлбал, өнөөдөр Дорнодын сав газарт Хятадын голдуу 40 орчим компани газрын тосны хайгуул, олборлолт хийж байна. Зөвхөн "Доншен газрын тос" ХХК-ны үйл ажиллагаа явуулж буй Дорноговь аймгийн Зүүн баянгийн Цагаан элсний орд газарт нөөц нь гэхэд 177 сая баррель бөгөөд дээрхи компани зөвхөн энэ жил гэхэд 70 гаруй мянган тонн түүхий нефтийг урагш гаргах төлөвлөгөөтэй ажиллаж байна. 2011 оны 4-р сард Улсын Мэргэжлийн Хяналтын Газраас хийсэн шалгалтаар Дорнод аймагт газрын тос олборлолт хийж бүтээгдхүүн хуваах гэрээгээр ажиллаж байгаа Хятад улсын компаниуд 13 жилийн турш Монгол Улсад роялти татвар огт төлж байгаагүй бөгөөд энэ нь олон арван сая америк долларын хэмжээнд хүрсэн болохыг илрүүлж эргэн төлүүлэх асуудлыг тавилаа. Энэ баримт бол манай улсын төрийн бодлого өөрийн орны эдийн засгаа гадаад ертөнцөд аажмаар, дэс дараалалтай нээсэн Япон, БНСУ, Азийн бар орнуудынхаас эрс өөр харин Африкийн улсуудын бүх зүйл рүү гадаадын капитал хяналтгүй орох бололцоо олгосон бодлоготой адилхан харагдаж байна. Азийн орнууд зах зээлд орох эхлэл тавигдсанаас хойш хорин жилийн дараа буюу эрчимтэй хөгжсөн нэгэн бүтэн үе өнгөрсний дараа л зах зээлээ нээж хориг саадыг аажмаар авч эхэлснийг дээр тодорхой дурдсан билээ.



Азийн бар, эрчимтэй хөгжиж буй орнууд төдийгүй өрнөдийн өндөр хөгжсөн орнууд хүртэл эдийн засагт нь хөгжиж буй орнууд хохирол учруулж мэдэх салбаруудаа өнөө үед ч гэсэн хамгаалсаар байна. Гэтэл манай улсад энэ чиглэлд төрийн бодлого илт үгүйлэгдэж энэ иргэний хөдөлгөөнүүдийг хүч хэрэглэх, тулган шаардах шинжтэй идэвхитэй үйл ажиллагаанд түлхсээр байна. Айванхоу Майнз компани нь Оюутолгой ХХК-ны 66%, Овоот толгойн нүүрсний ордод үйл ажиллагаа явуулж буй "Саусови Ресоурсез"-ийн 57%-ийг эзэмшиж байна. Ховд аймгийн Хөшөөтийн уурхайг 1967 онд улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нүүрсний нөөцтэйг нь анх илрүүлсэн байдаг ч 3 жилийн өмнө БНХАУ-ын 100%-ийн хөрөнгө оруулалттай МОЭНКО компани худалдан авч лицензийг нь эзэмшигч болсон. 2007 онд УИХ стратегийн ордын жагсаалтыг батлахад Хөшөөтийн орд 23.5 сая тонн нүүрсний нөөцтэй мөртлөө энэ жагсаалтанд оролгүй сугарч үлдсэн. Одоо Мозенко компани дангаараа нүүрс экспортлоод эхэлчихсэн бөгөөд Үндсэн хуулиар баялагын эзэн гэж зарлагдсан ард түмэн тэнд ямарч хувьцаа эзэмшдэггүй байх ажээ. Гэтэл үүнээс бага нөөцтэй Баян тээг, Нүүрст хотгорыг стратегийн ордод оруулсан байдаг. Эдгээр баримтууд нь улс орноо авч явах хамгийн гол салбараа төр огтхон ч хамгаалж чадахгүй байгаагийн жишээ мөн.

Өнөөдөр намууд сонгуулийн үр дүнгээс үл хамаарч эрх мэдлээ хуваан эрх барьж байгаа нь хувиа бодсон элитүүд улс төр, эдийн засгийн эрх мэдлийг монополичилж байна гэсэн дургүйцэл бас гадаад дотоод том бизнес бүлэглэлүүд хоорондоо хэт дотносох, хувийн сонирхлоор холбогдож бие биедээ яа тал зассан улс төрийн бүлэг байна гэсэн бухимдал бий болгосон байна.

Өөрийн улс орны эрх ашиг, онцлог, хөгжлийн учир начирыг гадаадын хөндлөнгөөс ажиглагчаас илүү өөрсдөө ойлгож түүндээ тохирсон улс төрийн бодлого явуулж чадна. Зөв бодлогыг гаднаас авч ирнэ гэдэг нь их эргэлзээтэй. Гэтэл манай улсад эдийн засгийн томоохон асуудлууд дээр гаднын зөвөлгөө, гаднын компанийн оролцоогүйгээр шийдэж байгаа асуудал ховор болсон бөгөөд нийгмийн зүгээс үүнд ихээхэн шүүмжлэлттэй хандаж байгаач эсэргүүцэл үр дүнд хүрч байгаа нь төдийлөн харагдахгүй байна.

Төр хээл хахууль, ёс зүйн ялзралд автах тусам иргэдийн дунд шударга ёсны үнэлэмж буурч, сонгогчид шударга бус байлыг тоомсорлохоо больж, аргагүйн эрхэнд авилгач төрийн ааш авирт тохируулж түүнтэй харьцахдаа өөрдсөө бас хууль завхруулахад хүрдэг байна.

Улс орны эдийн засаг сул дорой, үндэсний аж ахуйн нэгжүүд хөл дээрээ баттай зогсож чадаагүй байгаа өнөө үед чөлөөт эдийн засгийн өрсөлдөөнийг төрийн зохицуулалтгүйгээр дөвийлгөн хөгжүүлэх нь хэдэн зуун жилийн турш амжилттай хөгжиж ирсэн хөгжингүй орнуудыг эдийн засгийг дөнгөн данган байр сууриа олж хөгжих гэж ядаж байгаа буурай хөгжилтэй өөрийн орны бизнес эрхлэгчидтэй яг адил нөхцөлтэй өрсөлдөөнд оролцохыг тулган хүлээлгэж байгаа хэрэг бөгөөд энэ нь зүйрлэн хэлбэл хөлд орох гэж ядаж буй балчир хүүхдийг нас идэр хүнтэй гүйлтийн тэмцээнд өрсөлдүүлж байгаагаас ялгаагүй юм.

Бидний эх захгүй ярьж, хөгжил дэвшилд хүргэх ганц зам мэт сонгож байгаа дэлхийчлэл, энэ үйл явцтай холбоотой гарч ирсэн дэлхий нийтийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байдаг байгууллагуудын үйл ажиллагааг эсэргүүцсэн үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн манай оронд л байдаггүй зүйл болохоос биш аль хэдийнээ хуучин зүйл болсон ажээ. Ийм тэмцэл хөдөлгөөнүүд нь өндөр хөгжсөн орнуудын үндэстэн дамнан үйл ажиллагаа явуулдаг том компаниуд, тэдгээрийн нөлөө маш их тусгагдсан олон улсын байгууллагуудын эдийн засгийн хатуу чанга бодлого тэсвэрлэх аргагүй болох үед хөгжиж буй орнуудад хэдэн арван жилийн турш ажиглагдаж байгаа ажээ.

Аливаа байгууллагын шийдвэр мэдээж хэрэг шийдвэр гаргачдын үзэл бодол ашиг сонирхлыг илэрхийлж байдаг. Олон улсын эдийн засгийн байгууллагуудын бодлого нь ихэнхдээ өндөр хөгжилтэй орнуудын ашиг сонирхлын дагуу явагддаг. Манай улсад ч өргөн хүрээтэй явуулдагтай адил, ядуурлыг бууруулах чиглэлээр олон улсын байгууллагуудын зүгээс хэрэгжүүлдэг төсөл хөгжиж буй олон оронд хэрэгжсэн ч үнэндээ ядуу амьдралтай хүмүүсийн тоо тасралтгүй өсч ирсэн байдаг байна. Монголд ажилгүйдэл 2008 оноос 2009 онд 32%-иар өссөн. Одоо орон даяар ажилгүй 150000 гаруй хүн байгаагийн идэвхитэй ажил хайж байгаа 50000 хүн бий. Жил бүр 60000 орчим оюутан их дээд сургууль төгсөж байгаагийн 30% нь л ажилтай болдог байна. Ард иргэдээ ажилтай болгоход төрийн ухаалаг бодлого юу юунаас илүү чухал юм. Гадаадад 200000 орчим монголчууд ажил хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд ихэнхдээ ажилд сайн гэж үнэлэгддэг ажээ. Гэтэл эдгээр ажилчдын оронд хятадаас олон мянган ажилчид манай улсад ирж ажиллаж, монгол иргэдээс илүү цалин хөлс авч байгаа нь төрийн бодлогоор л зохицуулагдах асуудлын нэг мөнөөс мөн билээ. Нинжа нар гэхэд 50 метр орчим цооногыг гараар ухаж байгаа нь нэг талаас монгол хүмүүсийн ажилсаг байдлыг л харуулах бөгөөд нөгөө талд ажиллах хүчний энэ их нөөцийг ашиглаж, зохицуулж чадахгүй байгаа төрийн бодлого муу байгааг л харуулах билээ.

Улс төрийн бодлогоо өөрсдөө ухаалгаар явуулсан улс орнуудад эдийн засгийн өсөлтөө ч хангаж чадсан, ард иргэдийнхээ амжиргааг ч өсгөж чадсан нь байдаг. Өнөөгийн улс төрийн бодлого нь эдийн засгийн оновчтой бодлогоос хол, хүмүүст л таалагдах гэсэн шинжтэй байна. Иймч учраас эдийн засгийн тооцоо муутай их мөнгөний амлалтууд, нийлбэр дүнгээрээ улс оронд маш чухал ач холбогдолтой асуудлыг шийдэж чадахуйц мөнгийг хүн бүрт хишиг хүртээх чиглэлээр тарааж үрэн таран хийж байгаад иргэд ихээхэн шүүмжлэлтэй хандаж улс төрийн бодлогыг эдийн засгийн хувьд эрүүл тооцоотой хүмүүс түлхүү авч явах нь илүү оновчтой гэсэн нийтлэг нэг үзэл бодол давамгайлж байна. 2009 онд л гэхэд улсын төсвийн талаас илүү хувийг халамжийн чиглэлд урсгажээ.

Төр засгийн оролцоог хамгийн бага байлгах гэсэн неолиберал хандлагын нөлөө хүчтэй байсан үе байсан хэдий ч сүүлийн жилүүдэд иргэд төрийн байгууллагуудыг ардчилсан, шударга, үйлчилгээг үр нөлөөтэй хүргэдэг, ер нь аливаа харш үйлдэл, үзэгдлүүдийг сөрөн зогсох чадвартай, хүчирхэг байлгахыг эрхэлзэх болсон нь нийтлэг байгааг анхаарах хэрэгтэй болжээ.

Манай эрх барьж байгаа улс төрийн хүчнүүдийн алдаа нь

- үнэтэй түүхий эдээ үнэ хүргэж худалдаалж чадахгүй байгалийн гаралтай сайн чанарын түүхий эдээ хиймэл материалаас хямдаар борлуулж байна.
- Монгол хүнээ, түүний оюуны чадавхийг муу ашиглаж байна.
- шинжлэх ухаанаа, эрдэмтэн мэргэдээ ашиглахгүй байна.
- Хэт гадаадыг шүтсэн бодлого явуулж байна.
- Гадаадын хөрөнгө оруулалт, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого хоёрт зохистой харьцаа алдагдаж хүчирхэг гадаадын капиталын өмнө үндэсний үйлдвэрлэл, бизнес хүчгүйдэн доройтож үүнийг зохицуулах талаар явуулж буй төрийн бодлого дэндүү хөшүүн хойрго байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого л давамгайлж байгаа болохоос гадаадын хөрөнгө оруулалтаас хамгаалах бодлого бариг үгүй гэхэд хилсдэхгүй.

Энэ бүгд нь эцсийн дүнд төрийн бодлого шийдвэр гаргачдын эх оронч байдал, ёс суртахуунлаг байдлаас үлэмж хамааралтай юм. Улс төрийн эрүүл тогтолцоо, төрийн зөв бодлого, төрийн албаны ёс зүй нь хөгжлийн үр шимийг иргэд тэгш хүргэх чухал нөхцөл билээ. Ёс суртахуун, хариуцлагын тухай бодохгүй бол улс төрийн ямарч бодлого ямарч ардчиллын замаар гарч ирсэн байна үр дүнд хүрэхгүй билээ.

**Abstract**

The article "History of the development of East Asian countries and the Mongolian government's strategy" discusses how Japan, South Korea and other Asian giants have relied on their sources rather than loans and financing from off shore for their growth of the economy.

The government of those countries were more keen to develop their national corporates which led the countries to a more fruitful state. However, the Mongolian government is not taking careful steps in protecting their sectors, especially those of strategically important sectors.

**Ашигласан ном**

1. Ганхүү Т. Олон Улсын Маркетинг УБ., 2008
2. Дэлхий дахины түүх. 2-р боть, ред. З.Баасанжав, УБ., 2003
3. Жозеф Стиглиц. Дэлхийчлэл ба түүний сэтгэлд эс нийцэх нь. УБ., 2007,
4. Людовиг фон Мизес Либерализм.
5. Монголын ардчиллын төлөвшил.МУ-ын ШУА. ФСЭХ. УБ.2011.
6. ШУА-ийн Дорно дахин, олон улс судлалын хүрээлэн. Япон Азийн "барс" үсрэнгүй хөгжсөн нь. УБ., 1994
7. Geoffrey Blainey "A short History of The 20<sup>th</sup> Century" Chicago 2006
8. "Баялагаасаа болж баяжсан хийгээд баларсан орнууд". Өнөөдөр сонин. Цуврал нийтлэлүүд. 2010